# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр Дугаар 832 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 6.4.4, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ:

1.Дорноговь аймаг дахь Политехник коллежийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхөөгүй боловч цаашид ашиглалтын шаардлага хангахгүй болсон, 2 нэрийн, нийт 8,857,000.00 (найман сая найман зуун тавин тавин долоон мянган) төгрөгийн балансын үнэ, 6,347,516.59 (зургаан сая гурван зуун дөчин долоон мянга таван зуун арван зургаан төгрөг тавин есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн, Дорноговь аймаг дахь Политехник коллежийн захирал Б.Адилбиш нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Д.НАРАНГЭРЭЛ

123007254

37-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн
832 дугаар тогтоолын хавсралт

## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Хөрөнгийн нэр, марк | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Ашиглалтад орсон он | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 6*20 хэмжээтэй зуны хүлэмж | ш | 1 | 2020.03.18 | 3,521,000.00 | 2,523,383.19 | 997,616.81 |
| 2 | 6*20 хэмжээтэй зуны хүлэмж | ш | 1 | 2020.03.18 | 5,336,000.00 | 3,824,133.40 | 1,511,866.60 |
| **НИЙТ ДҮН** | | | **2** | | **8,857,000.00 (найман сая найман зуун тавин тавин долоон мянган)** | **6,347,516.59 (зургаан сая гурван зуун дөчин долоон мянга таван зуун арван зургаан төгрөг тавин есөн мөнгө)** | **2,509,483.41 (хоёр сая таван зуун есөн мянга дөрвөн зуун наян гурван төгрөг дөчин нэгэн мөнгө)** |